

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 11 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2023 оны 12 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 11 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 50 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 90 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 4.6 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувь, 1.2 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Ур дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
		100%	90%	70%	50%		
1	2	3	4	5	6	7	8
50	45	1	2	-	2	-	95.8

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна”, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт-ын хүрээнд “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд үр дүнтэй буюу 100, 94.4, 100 хувиар, Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний

бүртгэл, хяналтыг сайжруулна” арга хэмжээнд тусгагдсан ажил тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан иргэний хяналтыг сайжруулна	1	-	1	-	-	-	90
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	9	9	-	-	-	-	100
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	36	32	-	2	-	2	94.4
4	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	4	4	-	-	-	-	100
Нийт		50	45	1	2		2	96.1

Чиглэл тус бүрээр авч үзвэл Виз, зөвшөөрлийн газар, Иргэний харьяаллын газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Өмнөд бүс дэх газар, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Хангалт үйлчилгээний хэлтсийн хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувиар үнэлэгдсэн. Харин үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: Гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн гүйцэтгэлтэй-1, нийт 1 арга хэмжээ;
- Санхүүгийн хэлтэс: Шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн гүйцэтгэлтэй-1, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн гүйцэтгэлтэй-2 нийт 3 арга хэмжээ;
- Мэдээллийн технологийн хэлтэс: Үр дүнг нэмэгдүүлж, бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай буюу 90 хувийн гүйцэтгэлтэй-1, нийт 1 арга хэмжээ байна.

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Захиргаа, удирдлагын газар	20	19	-	1	-	98.5
2	Виз, зөвшөөрлийн газар	4	4	-	-	-	100
1	2	3	4	5	6	7	8

3	Иргэний харьяаллын газар	3	3	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	100
5	Санхүүгийн хэлтэс	3	-	-	1	2	43.3
6	Хангалт үйлчилгээний хэлтэс	1	1	-	-	-	100
7	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	5	5	-	-	-	100
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	2	2	-	-	-	100
9	Мэдээллийн технологийн хэлтэс	4	3	1	-	-	97.5
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	3	3	-	-	-	100
11	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	100
12	Өмнөд бүс дэх газар	1	1	-	-	-	100
Нийт		50	45	1	2	2	94.9

Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Санхүүгийн хэлтэс хамтарсан 1, нийт 4 арга хэмжээг хамтран гүйцэтгэсэн бөгөөд тус тус 100 хувиар үнэлэгдсэн.

#### Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2023 оны 11 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 50 арга хэмжээний нийт хэрэгжилт 95.8 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

##### 1. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувьтай үнэлэгдсэн

- “Шинээр нэвтрүүлж буй санхүүгийн нэгдсэн системээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах бэлтгэл ажлыг хангах” арга хэмжээний төлөвлөлт дээр анхаарч, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах мөн 1-3 дугаар улирлын бүх гүйлгээг байршуулсан байх;

- “Үнэ шинэчлэн тогтоох, актлах хөрөнгийн саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх” Хууль зүй, дотоод хэргийн яаманд саналыг албан бичгээр хүргүүлэх;

##### 2. “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай үнэлэгдсэн

- “Архивын цаасан суурьтай 2018-2022 оны байнга ба түр хадгалах баримтад тооллого хийх” ажлыг удирдлагад илтгэх хуудсаар танилцуулж эцэслэх;

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих” арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх; 12 дугаар сард тус арга хэмжээг эрчимжүүлж гэрээ дүгнэсэн акт үйлдэх;

3. 90 хувьтай үнэлэгдсэн

- “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг нэмэгдүүлж, системийн үйл ажиллагааг жигдрүүлэх;

4. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 45 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР